



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 63

Мандалговь

Орон нутгийн өмчөөс төрийн өмчид
хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 7,500,000 /долоон сая таван зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй, 1,125,000 /нэг сая нэг зуун хорин таван мянга/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Архивын нягтруулсан шүүгээг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлэх хөрөнгийн харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Адъяасүрэн)-д даалгасугай.


3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Доржбат), Төрийн аудитын газрын дарга (Р.Мөнхтогтох) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1 Шилжүүлэх хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.2. Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
63 дугаар тогтоолын хавсралт



Аймгийн Засаг даргын Тамгын газраас Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газарт шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэрс	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Архивын нягтруулсан шүүгээ	2022он	ширхэг	6.00	1,250,000	7,500,000	1,125,000	6,375,000	Төрийн аудит
дүн						7,500,000 /долоон сая таван зуун мянга/ төгрөг	1,125,000 /нэг сая нэг зуун хорин таван мянга/ төгрөг	6,375,000 /зургаан сая гурван зуун далан таван мянга/ төгрөг	